МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр Дугаар А/161 Мөрөн сум

Улсын төсвийн хөрөнгөөр бэлчээрийн
хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 15 дугаар зүйлийн 15.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай" 2024 оны 02 дугаар сарын 15-ний А/96 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, микробиологийн бэлдмэл суманд олгох хуваарилалтыг хоёр дугаар хавсралтаар, 2024 онд Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой энгийн механик, биологийн аргаар тэмцэх арга хэмжээнд хамрагдах сумдын нэр, тэмцэх талбайн хэмжээ, шаардагдах төсвийн хуваарь болон ажлын гүйцэтгэлд хийх хяналтын зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг технологийн хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг улс, орон нутгийн төсвийн эх үүсвэрээр тус тусад нь гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг орон нутагт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын Газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6710010485

Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дугаар
сарын 08-ны өдрийн А/05 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НЭР БҮХИЙ СУМДАД БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Я.Эрхэмбаяр-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Д.Чинзориг-Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн,

Б.Бямбасүрэн-Мал үржлийн албаны дарга,

Б.Тунгалаг-Хяналтын албаны ургамал хамгаалал, хорио цээрийн улсын байцаагч,

С.Гончигням- (Цагаан-Уул сумын Засаг дарга)

Н.Анхбаяр-(Цэцэрлэг сумын засаг дарга)

Ц.Бямбажав- (Жаргалант сумын Засаг дарга)

М.Бат-Эрдэнэ- (Шинэ-Идэр сумын Засаг дарга)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Т.Пүрэвхүү-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны Малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дугаар
сарын 08-ны өдрийн А/16 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ БОЛОН БАКТЕРЖУУЛСАН БУДААНЫ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Сумын нэр	Тэмцэх талбай хэмжээ мян.га	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хуваарилах бактержуулсан будаа хэмжээ, тн	Микробиологийн бэлдмэлийг талбайд цацахад шаардлагатай орон нутгийн төсөв, сая.төг
1.	Цагаан-Уул	10.0	15.0	21.50
Нийт дүн		10.0	15.0	21.50

Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дугаар
сарын 08-ны өдрийн А/161 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ 2024 ОНД ЭНГИЙН МЕХАНИК , БИОЛОГИЙН АРГААР ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДАХ СУМДЫН НЭР, ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ШААРДАГДАХ ТӨСВИЙН ХУВААРЬ, ХЯНАЛТЫН ЗАРДАЛ

Д/д	Сумын нэр	Мэрэгчтэй тэмцэх шаардлагатай талбайн хэмжээ, мян.га				Зарцуулах хөрөнгө, мян.төг	
		Урьд оны тэмцсэн хийсэн талбай	Сумын санал	Оготно тархсан талбайн хэмжээ	Хүнс, хөдөө аж ахуйн газрын төлөвлөлт	Улсын төсөв	Сумын баталсан эх үүсвэр
1.	Цэцэрлэг	10.0	13.0	200.0	13.0	18,720.0	3,500.0
2.	Жаргалант	-	8.0	15.0	7.0	10,080.0	3,000.0
3.	Шинэ-Идэр	-	10.0	50.0	10.0	14,400.0	-
Хяналтын зардал		-	-	-	-	4,200.0	-
Дүн		10.0	31.0	265.0	30.0	47,400.0	6,500.0